

1.4. Баталгаажуулах хүсэлт

1.4 Баталгаажуулах хүсэлт

Аймаг, нийслэлийн боловсрол газраас ирсэн шинэ суралцагчийн бүртгэлтэй холбоотой баталгаажуулах хүсэлтийг энэ цонхны тусламжтайгаар шийдвэрлэнэ.

1. **Хичээлийн жил** -ийг энэ хэсгээс сонгоно. Өмнөх хичээлийн жилийн мэдээллийг түүх байдлаар харах боломжтой.
2. **Хүсэлтийн төрөл** хэсгээс “Шинэ суралцагч нэмсэн”, “Хөтөлбөр хооронд шилжсэн”, “Экстранат” төрлүүдээр шүүлт хийж болно.
3. **Хүсэлтийн төлөв** хэсгээс “Хянагдаж байгаа”, “Батлагдсан”, “Цуцлагдсан” сонголтууд хийж 7-р хэсгийн жагсаалтыг өөрчилж болно.
4. **Байгууллага** хэсгээс Ерөнхий боловсролын сургууль эсвэл Цэцэрлэг сонголтыг хийж хүсэлт илгээсэн байгууллагын төрлийг сольж болно.
5. **Харьяалал** -аар нь ирсэн баталгаажуулах хүсэлтүүдийг энэ хэсгээс сонголт хийж тухайн аймаг, дүүргийн түвшинд нарийвчлан харж болно. Жич: Жагсаалтаас “Нийслэл” -ийг сонгож Дүүрэг тус бүрээр дэлгэрүүлэн харж болно. Аймаг, дүүргийн сонголт хийсний дараа жагсаалтыг дахин задалж цэцэрлэг/сургууль бүрээр шүүж харах боломжтой. Улсын хэмжээний нэгтгэлийн харахдаа дээд талын БСШУСЯ -гэснийг сонгоно уу.
6. **Хайлт** хэсэгт суралцагчийн нэр эсвэл регистрийн дугаарыг оруулж баталгаажуулах хүсэлтийн жагсаалтаас хайлт хийх боломжтой.
7. Баталгаажуулах хүсэлтийн **жагсаалт**
8. Тухайн нэг баталгаажуулах хүсэлтийн **дэлгэрэнгүй мэдээлэл**
9. Тухайн нэг баталгаажуулах хүсэлттэй холбоотой **нэмэлт тайлбар**. Тайлбар дээр дарж дэлгэрэнгүй харах боломжтой.
10. Тухайн хүсэлтийг сонгож Баталгаажуулах эсвэл Цуцлах үйлдлийг хийж болно.